



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА М.ЭНХБОЛД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30

2018.02.02 № 322
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалин хөлсийг Төрийн аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3. дахь заалт, 28.7.-д заасны дагуу Улсын Их Хурал тогтоохоор зохицуулалттай боловч дээрх заалтуудыг 2003 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлээгүй, энэ талаар шийдвэр гараагүй байна.

Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасны дагуу "ажиллах нөхцөл баталгааг"-аар төр хангах үүрэгтэй тул Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалин, холбогдох нэмэгдлийг тогтоох шаардлагатай байна.

Энэ талаар төсөл боловсруулан Төрийн албаны зөвлөлөөс санал авч хүргүүлж байна.

Хэлэлцэн баталж өгнө үү.

Хавсралт 31 хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

ТАНИЛЦУУЛГА

“Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Төрийн аудитын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7¹.1, 7¹.2-т төрийн аудитын байгууллага нь Монгол Улсын Ерөнхий аудитор, тэргүүлэх аудитор, аудитын менежер, ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээчээс бүрдэнэ, эдгээр албан хаагч нь төрийн тусгай албан хаагч байна гэж тодорхойлсон бөгөөд мөн Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3-т “... Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах ба гүйцэтгэх албан тушаал” –ыг төрийн тусгай алба байхаар тодорхойлсон.

Төрийн албаны тухай хуулийн 28.2.3-т тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ гэж заасан.

Гэтэл өнөөгийн байдлаар Төрийн аудитын байгууллагын албан хаагчид төрийн алба хаасан хугацааны, албан ажлын онцгой нөхцөлийн, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох хувь хэмжээ тогтоосон шийдвэр байхгүй тул төрийн бусад байгууллагын жишгийг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудитор нэмэгдлийн хэмжээг тогтоон олгож ирсэн байна. Тухайлбал:

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар, Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 25-39 хувиар, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10-30 хувь байна.

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7-д “... тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн хууль тогтоомжоор тогтооно” гэж заасан байхад Монгол Улсын Ерөнхий аудитор тогтоож ирсэн байна.

Иймд дээрх зөрчлийг арилгаж Төрийн аудитын байгууллагын албан хаагчид олгох нэмэгдэлийн хэмжээг хууль тогтоомжийн дагуу баталгаажуулах шаардлага байх тул төрийн тусгай албанд олгодог төрийн алба хаасан хугацааны, албан ажлын онцгой нөхцөлийн, мэргэшлийн зэргийн нэмэгдлүүдийн хэмжээг тогтоохоор боловсрууллаа.

Уг тогтоолын төсөл батлагдсанаар Төрийн аудитын байгууллагын цалингийн зардалд өөрчлөлт орохгүй бөгөөд одоо олгож буй хувь хэмжээгээр цалингийн сандаа багтаан олгох боломжтой болно.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл нь Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд боловсруулагдсан бөгөөд тогтоолын төсөл болон Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн нэмэгдлийн хэмжээг тогтооно.

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар, албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хүртэл хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 35 хүртэл хувиар

тогтоох бөгөөд тус нэмэгдлийг олгох журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн албаны хууль тогтоомжид нийцүүлэн тогтоохоор тусгана.

Төрийн албаны тухай хуулиар Төрийн аудитын байгууллагын тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн нэмэгдлийн хэмжээ, зайлшгүй шаардлагатай бусад хангамжийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох зохицуулалттай тул хэлэлцэн баталж өгнө үү.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛ**

2018 оны ...сарын ... өдөр

Дугаар _____

Төрийн ордон, Улаанбаатар хот

**Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн
нэмэгдлийн хэмжээ тогтоох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсгийг үндэслэн
ТОГТООХ нь:

1.Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн нэмэгдлийн хэмжээг дараах
байдлаар тогтоосугай.

- 1/Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 5-25 хувиар;
- 2/албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг 30 хүртэл хувиар;
- 3/мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 35 хүртэл хувиар;

2.Дээрх нэмэгдлийг олгох журам, шалгуур үзүүлэлтийг төрийн албаны тухай хууль
тогтоомжид нийцүүлэн баталж, албан тушаалын үндсэн цалингаас сар бүр тооцож
олгохыг Монгол Улсын Ерөнхий аудитор /Д Хүрэлбаатар/-т даалгасугай.

3.Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

М.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.ХҮРЭЛБААТАР ТАНАА

**МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2017.12.19 № 1395


танай _____-ны № _____-т

Санал өгөх тухай

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс санал авахаар Танаас ирүүлсэн "Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын цалингийн хэмжээ тогтоох тухай" болон "Төрийн аудитын байгууллагын албан хаагчид нэмэгдэл олгох журам батлах тухай" Улсын Их Хурлын тогтоол, журмын төсөлтэй танилцлаа.

Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг хараат бусаар хэрэгжүүлэх болон тус байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг сайжруулах үүднээс цалин, нэмэгдлийг шинэчлэх талаар боловсруулсан Улсын Их Хурлын тогтоол, журмын төслийг зарчмын хувьд дэмжиж байна.

ДАРГА



Б.ЦОГОО